



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/219

Мандалговь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8 дах хэсэг, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 1-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл, ХХААХҮ-ийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тов мэдээг малчид, мал бүхий иргэдэд хүргэн, бэлэн байдлыг хангуулж, үхэр сүргийг бүрэн хамруулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


2. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (И.Жавхланта), захирамжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  М.АНХБАЯР



4822100521


  
 Аймгийн Засаг даргын 2023 оны  
 04 дугаар сарын 15-ны/ний өдрийн  
 04 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Шүлхийн дархлаажуулалтад хамрагдах малын тоо  
вакцины хуваарь

№	Сумын нэр	Өрхийн тоо	Малын тоо			Олгох вакцин /тун/
			Үхэр	Гахай	Нийт	
1	Дэлгэрцогт	375	4198		4198	4200
2	Дэрэн	466	4423		4423	4500
3	Говь-Уггаал	289	3159	37	3196	3200
4	Цагаандэлгэр	261	3073		3073	3100
5	Баянжаргалан	249	3549		3549	3600
6	Өндөршил	294	4437		4437	4500
7	Гурвансайхан	519	4692	22	4714	4800
8	Өлзийт	644	3070		3070	3100
9	Хулд	539	2975		2975	3000
10	Луус	398	5074		5074	5100
11	Дэлгэрхангай	433	1870	2	1872	1900
12	Сайхан-Овоо	430	3021		3021	3100
13	Эрдэнэдалай	1308	14008		14008	14000
14	Сайнцагаан	928	5855	86	5941	6000
15	Адаацаг	549	6516		6516	6600
	<b>Аймгийн дүн</b>	<b>7682</b>	<b>69920</b>	<b>147</b>	<b>70067</b>	<b>70700</b>